

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засгийн газрын нөөц сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/08//НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхбаатар Утас: 261740 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn Аудитор: О.Наранбат Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ж.ГАНБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.03.24 № 07/657

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Засгийн газрын нөөц сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Засгийн газрын нөөц сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 48 тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас зарцуулалт гаргах эрхийг олгосон байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын тогтоолоор гамшиг, аюулт үзэгдэл, түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгахад 16,402,682.8 мянган төгрөг, Улсын их хурал, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд 39,563,777.6 мянган төгрөг, олон улсын шүүх, арбитраг хариуцагчаар татагдсан, тэдгээрээс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд 5,212,252.7 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 21,286.9 мянган төгрөгийг тогтворжуулалтын санд төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ӨЗӨН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
33	АВЛАГА	-	-
33500	Бусад авлага	-	-
33510	Байгууллагаас авах авлага	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
41300	Өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	-
51	Засгийн газрын хувь оролцоо	-	-
51200	Хуримтлагдсан үр дүн	-	-
51210	Өмнөх үеийн үр дүн	-	-
51220	Тайлант үеийн үр дүн	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	100,000,000,000.00	61,200,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	100,000,000,000.00	61,200,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	100,000,000,000.00	61,200,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	100,000,000,000.00	61,200,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	100,000,000,000.00	61,200,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100,000,000,000.00	61,200,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,000,000,000.00	61,200,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,731,951,791.41	61,178,713,152.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,731,951,791.41	61,178,713,152.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	268,048,208.59	21,286,847.54
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	268,048,208.59	21,286,847.54
213306	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	268,048,208.59	21,286,847.54
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	100,775,986,486.24	61,640,750,764.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	775,986,486.24	440,750,764.81
120	Нийтлэг татварын бус орлого	775,986,486.24	440,750,764.81
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	775,986,486.24	440,750,764.81
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	775,986,486.24	440,750,764.81
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	100,000,000,000.00	61,200,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	100,000,000,000.00	61,200,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	100,000,000,000.00	61,200,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	100,775,986,486.24	61,640,750,764.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100,775,986,486.24	61,640,750,764.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,507,938,277.65	61,619,463,917.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,507,938,277.65	61,619,463,917.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,507,938,277.65	61,619,463,917.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	268,048,208.59	21,286,847.54
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	268,048,208.59	21,286,847.54
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	268,048,208.59	21,286,847.54
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗГ-ын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	ЗГ-ын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31- нэрэх үлдэгдэл	-	-	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэлийн	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,200,000,000.00	61,178,713,152.46	21,286,847.54	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	61,200,000,000.00	61,178,713,152.46	21,286,847.54	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,200,000,000.00	61,178,713,152.46	21,286,847.54	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	61,200,000,000.00	61,178,713,152.46	21,286,847.54	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	61,200,000,000.00	61,178,713,152.46	21,286,847.54	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,200,000,000.00	61,178,713,152.46	21,286,847.5-	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,200,000,000.00	61,178,713,152.46	21,286,847.5-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	61,200,000,000.00	61,178,713,152.46	21,286,847.54	100.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,214,800.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй асуудалд 1 албан шаардлага хүргүүлж, 1,214,800.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

3.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Засгийн газрын 2020 оны 139, 240 дүгээр тогтоолуудаар хэрэгжүүлсэн 359,000.0 мянган төгрөгийн арга хэмжээ нь төсвийн 3 жил дамжин хэрэгжсэн байна	1	-		1	-							
Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал төсвөөс санхүүжүүлэх боломжтой 1,214,800.0 мянган төгрөгийг ЗГНС-аас зарцуулсан байна.	1	1,214,800.0				1	1,214,800.0					
Дүн	2	1,214,800.0		1	-	1	1,214,800.0					

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.